

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ЗАХИРАЛ О.ЯНЖМАА ТАНАА

2020.03.13 № 06/812
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус зөвлөлийн ажлын албаны захирал О.Янжмаа Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын талаар өгсөн зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 03-наас 2020 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн аудитор Ж.Үхэртар хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 66 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Сургалтын чанарыг дэмжиж, дээд, мэргэжлийн боловсролын байгууллага, хөтөлбөрийн үндэсний стандартыг сахиулж, олон улсын хэмжээнд боловсролын үнэлэмж, байр суурийг бэхжүүлэхэд оршино.

Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 240 дүгээр тогтоолоор Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Боловсролын байгууллагын магадлан итгэмжлэл
- ✓ Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
- ✓ Шинээр нээх сургалтын хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01 дугаар тогтоолоор магадлан итгэмжлэлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа программ хангамж ашигладаггүй байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад хяналтын зөвлөл нь дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 чиглэлд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 404.8 сая төгрөгөөс тооцон 8.1 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тооцоходоо хувь хэмжээг өөрчлөөгүй 2.0 хувиар, суурь үзүүлэлтийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоор сонгож 19.0 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 113.7 сая төгрөгөөр буюу 61.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	128.4	204.2	75.8
Авлага	0.2	2.0	1.8
Урьдчилгаа	-	0.7	0.7
Бараа материал	-	3.0	3.0
Үндсэн хөрөнгө	55.6	87.9	32.3
Нийт хөрөнгө	184.2	297.8	113.6
Өр төлбөр	10.5	216.0	205.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	173.7	81.8	-91.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	184.2	297.8	113.6

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл өмнөх тайлант үеэс 1.8 сая төгрөгөөр өссөн нь 2.0 сая төгрөгийн ажилчдаас авах авлагын тооцоо үүссэнээс шалтгаалсан байна. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон, барагдах боломжгүй, эрсдэлтэй авлагууд байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.0 сая төгрөгөөр өссөн нь 2019 онд худалдаж авсан 2.5 сая төгрөгийн аж ахуйн материал, 0.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан эргэлтийн хөрөнгийг ангилал өөрчилж бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 32.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 9.5 сая төгрөгийн тавилга эд хогшил, 29.2 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл худалдаж авсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх тайлант оны үлдэгдлээс 205.5 сая төгрөгөөр өссөн нь 215.8 сая төгрөгийн магадлан итгэмжлэлийн бүртгэлийн хураамж, суурь хураамж, хувьсах зардлын төлбөрүүд 2019 оны 4 дүгээр улиралд орж ирсэнтэй холбоотойгоор урьдчилж орсон орлого дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Бусад 0.2 сая төгрөгийн өр бүртгэгдсэн байгаа бөгөөд энэ нь хувь хүний орлогын албан татварын өглөг байна.

2.9. Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны захирал нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдтай тухайн тайлант жилд хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор үр дүнгийн гэрээ байгуулдаг бөгөөд 2019 оны үр дүнгийн гэрээг 2019 оны 2 дугаар сарын 4-ний өдөр байгуулсан байна.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь тайлант онд 1,011.4 сая төгрөгийн орлого, 1,115.7 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 950.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,042.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Төлөвлөсөн орлогоос 121.3 сая төгрөгийг дутуу бүрдүүлж, зардлыг 73.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 1. Орлого зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны	695.5	538.1	-157.4	77.3
Туслах үйл ажиллагааны	15.0	16.2	1.2	108.0
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	50.9	146.4	95.5	287.6
Улсын төсвийн санхүүжилт	250.0	250.0	-	100.0
Нийт дүн	1,011.4	950.7	-121.3	93.9
Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсвийн зарцуулалт	250.0	250.0	-	100.0
Өөрийн орлогоос	865.7	792.5	73.2	91.5
Нийт дүн	1,115.7	1,042.5	73.2	93.4

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 8.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар шинжээчдийн цалин, байгууллагын магадлан итгэмжлэл, хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, урьдчилсан магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны асуудлыг анхаарч авч үзэхээр шийдвэрлэсэн.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны мэдээллийн цахим хуудсанд цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын нийт 3 удаагийн 33.5 сая төгрөгийн гүйлгээ, төсөв зарцуулах шийдвэрийн тухай 5 удаагийн 17.2 сая төгрөгийн гүйлгээг тус тус хугацаанд нь мэдээлсэн байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 344.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, байгууллагын статустай холбоотой шийдвэрлэхээр өгсөн 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, хяналтын зөвлөлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 60.0 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, хөтлөлт, санхүүгийн тайлагналд нөлөө үүсэх, холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг мөрдөж ажиллаагүй байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Батлагдсан төлөвлөгөөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны захирлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр тайлант онд 1,011.4 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байснаас гүйцэтгэлээр 950.7 сая төгрөгийн орлого олж, 121.3 сая төгрөгийг дутуу бүрдүүлсэн байгаа нь төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Энэ нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 Ажлын албаны захирал дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. 8.4.3-т "Ажлын албыг санхүүгийн удирдлагаар ханган хөрөнгө бүрдүүлэх, төсөв төлөвлөгөөний дагуу захиран зарцуулах, хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Байгууллагын өөрийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлэхэд хүндрэл үүсэх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг бодитой бөгөөд үндэслэлтэй төлөвлөж батлуулах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал /Цалингийн тооцоолол/

3.1. Илрүүлэлт:

- ✓ Мэргэжлийн зөвлөл болон комиссын хурлын гишүүдийн нийт тооцсон 17.7 сая төгрөгийн цалингаас 4.2 сая төгрөгийн НДШ-ийг тооцож төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй;
- ✓ Үндсэн ажилчдын ээлжийн амралтаас НДШ-ийг дутуу тооцсонтой холбоотой 0.3 сая, ХХОАТ-ын 0.05 сая төгрөгийг тус тус дутуу суутгасан, мөн бүтэн жил ажилласан ажилчдын цалинд ХХОАТ-ын хөнгөлөлтийн тохируулгыг хийгээгүй;
- ✓ Эрасмус төсөлтэй холбоотойгоор нийт 9 хүний цалингаас НДШ-ийг 3.4 сая, ХХОАТ-ыг 0.7 сая төгрөгөөр дутуу болон орхигдуулан тайлагнасан зөрчлүүд илэрлээ. Нийт дүнгээр НДШ-ийн өглөг 7.9 сая, ХХОАТ өглөг данс 0.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх, бодитой байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах"; Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөх үүрэг "1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Зардлын дүн илүү дутуу тооцогдох, санхүүгийн тайлан зөрүүтэй илэрхийлэгдэх

3.3. Өгсөн зөвлөмж:

Цалингийн тооцооллыг зөв хийж, холбогдох татвар шимтгэлийг хууль, журмын дагуу суутган тооцох.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	128,565,681.80	209,916,857.22
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	128,366,897.33	204,198,230.22
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	128,366,897.33	204,198,230.22
4	Төгрөг	91,501,573.67	158,633,415.79
5	Арилжааны банк дахь харилцах	91,501,573.67	158,633,415.79
5	Гадаад валют	36,865,323.66	45,564,814.43
6	Арилжааны банк дахь харилцах	36,865,323.66	45,564,814.43
7	АВЛАГА	198,784.47	2,000,000.00
8	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	198,784.47	0.00
9	Ажилчдаас авах авлага	-	2,000,000.00
10	Бараа материал	-	2,968,987.00
11	Хангамжийн материал	-	2,968,987.00
12	Урьдчилж төлсөн зардал	-	749,640.00
13	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	55,595,040.78	87,923,910.68
14	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	55,595,040.78	87,923,910.68
15	Биет хөрөнгө	55,595,040.78	87,923,910.68
16	Машин, тоног төхөөрөмж	27,090,277.00	27,090,277.00
17	Хуримтлагдсан элэгдэл	-22,274,227.70	-22,274,227.70
18	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,705,864.00	55,656,797.00
19	Хуримтлагдсан элэгдэл	-30,926,872.52	-17,004,970.10
20	Компьютер дагалдах хэрэгсэл	-	64,202,280.00
21	Хуримтлагдсан элэгдэл	-	-19,746,245.52
22	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	184,160,722.58	297,840,767.90
23	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,521,445.44	216,036,000.00
24	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	10,521,445.44	216,036,000.00
25	Өглөг	10,521,445.44	216,036,000.00
26	Бусад өглөг	10,521,445.44	202,643.00
27	Байгууллагад төлөх өглөг	10,521,445.44	202,643.00
28	Урьдчилж орсон орлого		215,833,357.00
29	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	173,639,277.14	81,804,767.90
30	Засгийн газрын хувь оролцоо	173,639,277.14	81,804,767.90
31	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн	42,480,772.28	42,480,772.28
32	Өмч: -Төрийн өмч	42,480,772.28	42,480,772.28
33	Хуримтлагдсан үр дүн	131,158,504.86	39,323,995.62
34	Өмнөх үеийн үр дүн	95,638,892.84	131,158,504.86
35	Тайлант үеийн үр дүн	35,519,612.02	-91,834,509.24
36	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	184,160,722.58	297,840,767.90

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	807,771,626.20	950,713,522.61
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	557,771,626.20	700,713,522.61
3	Нийтлэг татварын бус орлого	557,771,626.20	700,713,522.61
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	557,771,626.20	700,713,522.61
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,070,052.38	538,111,031.80
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,969,027.82	16,248,066.40
7	Гадаадын эх үүсвэрээр санхүүжих	47,732,546.00	146,354,424.41
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,000,000.00	250,000,000.00
9	Төсвийн захирагчдаас	250,000,000.00	250,000,000.00
10	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	250,000,000.00	250,000,000.00
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	769,074,850.08	1,042,548,031.85
12	УРСГАЛ ЗАРДАЛ	769,074,850.08	1,042,548,031.85
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	769,074,850.08	1,042,548,031.85
14	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	258,667,960.77	527,488,068.00
15	Цалин	223,785,833.77	267,931,590.00
16	Унаа хоолны хөнгөлөлт	34,882,127.00	45,392,727.00
17	Шинжээчдийн цалин	-	214,163,751.00
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,040,155.29	66,021,711.20
19	Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,693,436.86	44,016,674.86
20	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,586,679.60	5,499,608.54
21	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	5,173,359.22	11,005,819.26
22	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	517,335.92	1,102,562.58
23	Эрүүл мэндийн даатгал	2,069,343.69	4,397,045.97
24	Хангамж, бараа материалын зардал	40,049,593.50	102,228,240.98
25	Бичиг хэргийн материал	5,199,821.00	9,132,374.00
26	Тээвэр, шатахууны зардал	4,829,970.00	8,355,684.64
27	Шуудан холбоо интернетийн төлбөр	6,801,063.22	8,064,895.90
28	Ном хэвлэлийн зардал	4,720,334.06	69,183,236.44
29	Хог хаягдал устгах, цэвэрлэх	265,374.00	1,031,000.00
30	Аж ахуйн материал худалдан авах зардал	18,233,031.22	6,461,050.00
31	Эд хогшил, урсгал засварын зардал	17,890,000.00	45,435,060.00
32	Тавилга	17,890,000.00	38,611,700.00
33	Урсгал засвар	-	6,823,360.00
34	Томилолт , зочны зардал	28,969,484.60	83,599,153.80
35	Гадаад албан томилолт	27,673,684.60	78,929,253.80
36	Дотоод албан томилолт	1,295,800.00	4,669,900.00
37	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	377,229,820.22	191,920,028.27
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	377,229,820.22	191,920,028.27
39	Бараа үйлчилгээний бусад зардал	15,227,835.70	25,855,769.60
40	Сургалтын зардал	-	20,031,426.50
41	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,227,835.70	5,824,343.10
42	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	38,696,776.12	-91,834,509.24
43	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,177,164.10	-
44	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,177,164.10	-
45	НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	35,519,612.02	-91,834,509.24

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	807,771,626.20	1,254,712,671.61
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	557,771,626.20	1,004,712,671.61
3	Нийтлэг татварын бус орлого	557,771,626.20	1,004,712,671.61
4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	557,771,626.20	1,004,712,671.61
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	353,070,052.38	753,944,388.80
6	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	156,969,027.82	18,248,266.40
7	Гадаадын эх үүсвэрээр санхүүжих	47,732,546.00	232,520,016.41
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,000,000.00	250,000,000.00
9	Төсвийн захирагчдаас	250,000,000.00	250,000,000.00
10	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	250,000,000.00	250,000,000.00
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	751,184,850.08	1,140,269,638.72
12	УРСГАЛ ЗАРДАЛ	751,184,850.08	1,140,269,638.72
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751,184,850.08	1,140,269,638.72
14	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	258,667,960.77	495,450,530.90
15	Цалин	223,785,833.77	257,446,568.66
16	Унаа хоолны хөнгөлөлт	34,882,127.00	45,392,727.00
	Шинжээчдийн цалин	-	192,611,235.24
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,136,561.00	125,740,830.06
18	Тэтгэврийн даатгалын шимтгэл	38,355,868.52	83,831,411.40
19	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,315,035.21	10,474,211.14
20	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	9,588,967.13	20,960,996.37
21	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	958,896.71	2,099,871.86
22	Эрүүл мэндийн даатгал	1917793.43	8,374,339.28
23	Хангамж, бараа материалын зардал	40,049,593.50	137,338,458.26
24	Бичиг хэргийн материал	5,199,821.00	9,132,374.00
25	Тээвэр, шатахууны зардал	4,829,970.00	8,355,684.64
26	Шуудан холбоо интернетийн төлбөр	6,801,063.22	8,064,895.90
27	Ном хэвлэлийн зардал	4,720,334.06	69,183,236.44
28	Хог хаягдал устгах, цэвэрлэх	265,374.00	1,031,000.00
29	Аж ахуйн материал худалдан авах зардал	18,233,031.22	6,461,050.00
	Сургалтын зардал	-	20,031,426.50
	Мэдээлэл сурталчилгааны зардал	-	15,078,790.78
30	Эд хогшил, урсгал засварын зардал	17,890,000.00	6,823,360.00
31	Тавилга	17,890,000.00	
	Урсгал засвар	-	6,823,360.00
32	Томилолт , зочны зардал	28,969,484.60	169,764,745.80
33	Гадаад албан томилолт	27,673,684.60	165,094,845.80
34	Дотоод албан томилолт	1,295,800.00	4,669,900.00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	350,471,250.21	205,151,713.70
36	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	350,471,250.21	205,151,713.70
37	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	56,586,776.12	114,443,032.89
38	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,890,000.00	38,611,700.00
39	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,890,000.00	38,611,700.00
40	Дотоод эх үүсвэрээр	17,890,000.00	38,611,700.00

41	Үндсэн хөрөнгө худалдан авсан зардал	17,890,000.00	38,611,700.00
43	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	17,890,000.00	38,611,700.00
45	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	38,696,776.12	75,831,332.89
46	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	89,670,121.21	128,366,897.33
47	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	128,366,897.33	204,198,230.22

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,480,772.28		95,638,892.84	138,119,665.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн			35,519,612.02	35,519,612.02
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,480,772.28		131,158,504.86	173,639,277.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-		-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-		-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-		-	-
Тайлант үеийн үр дүн	-		-91,834,509.24	-91,834,509.24
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	42,480,772.28		39,323,995.62	81,804,767.90

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.10	Аудитын нэр:	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл			САГ-2020/112/СТА-ТӨҮГ
				сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулла гаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал, Нягтлан бодогч	О.Янжмаа Г.Отгон
2	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь үр дүнгийн гэрээний орлого зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Ажлын албаны захирал	О.Янжмаа
3	-Мэргэжлийн зөвлөл болон комиссын хурлын гишүүдийн нийт тооцсон 17.7 сая төгрөгийн цалингаас 4.2 сая төгрөгийн НДШ-ийг тооцож төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй; -Үндсэн ажилчдын ээлжийн амралтаас НДШ-ийг дутуу тооцсонтой холбоотой 0.3 сая, ХХОАТ –ын 0.05 сая төгрөгийг тус тус дутуу суутгасан, мөн бүтэн жил ажилласан ажилчдын цалинд ХХОАТ-ын хөнгөлөлтийн тохируулгыг хийгээгүй; -Эрасмус төсөлтэй холбоотойгоор нийт 9 хүний цалингаас НДШ-ийг 3.4 сая, ХХОАТ-ыг 0.7 сая төгрөгөөр дутуу болон орхигдуулан тайлагнасан зөрчлүүд илэрлээ. Нийт дүнгээр НДШ-ийн өглөг 7.9 сая, ХХОАТ өглөг данс 0.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	8.6	Зөвлөмж өгөх	Ажлын албаны нягтлан бодогч	Г.Отгон
	Дүн	8.6			

